



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/19

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 "а" дэх заалт, "Жишиг норм батлах тухай" Зам тээвэр, хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал, аймгийн Дотоод аудитын хорооны 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудын автомашины 100 км-д зарцуулах шатахууны нормыг шинэчилж, дагаж мөрдөх заавар журмыг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Б.Түвшинбаяр (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга Г.Мөнхбаясгалан (Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд Д.Нандинцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

С.Чинбат (Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын нягтлан бодогч)

Ц. Баярмагнай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын жолооч)

Хоёр. Харьяа байгууллагуудын тээврийн хэрэгсэл болон холбогдох эрх зүйн актын хүрээнд тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын нормыг судалж, ажлын зураг авалт хийн баталгаажуулан, шинэчилсэн нормыг дагаж мөрдөх журмыг 2021 оны 2 дугаар сарын 10-ны дотор багтаан батлуулахыг ажлын хэсэг (Б.Түвшинбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481213162